

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН  
2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

**Өмнөх үг**

Төсвийн олон байгууллагууд өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаандаа стратегийн удирдлагыг нэвтрүүлж үр дүнд хүрч байна. Стратегийн удирдлага, төлөвлөгөөг хэрэгжүүлснээр байгууллагын хөгжлийн ирээдүйн чиг хандлага, тэргүүлэх чиглэл тодорхой болж, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд үйл ажиллагаагаа нийцүүлэх боломж бүрдэж, удирдлага, зохион байгуулалт оновчтой болж, ажиллагсдын мэргэжлийн ур чадвар дээшлэн, гадаад, дотоод түншлэл, хамтын ажиллагаа өргөжих зэргээр байгууллагын хэвийн амжилттай ажиллах нөхцөл бүрддэг. Мөн удирдлагад байгууллагаа итгэлтэй, алсын хараатай удирдах, хамт олны үйл ажиллагааг нэг зүгт чиглүүлэх, төсвийг нэмэгдүүлэх боломжгүй нөхцөлд үйлчилгээний чанарыг бууруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх бололцоо олгодог.

Стандарт хэмжилзүйн хэлтсийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх нь ирэх дөрвөн жилд баримтлах үйл ажиллагааны зорилго, чиглэл, арга замуудыг тодорхойлж, үндэсний чанарын дэд бүтцийн эрх зүйн орчныг цаашид олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгох замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн бодлого, хууль тогтоомж, стандарт хэмжилзүйн асуудал эрхэлсэн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

**Ерөнхий менежерийн мэдэгдэл**

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ**

Дархан-Уул аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс нь орон нутагт Монгол улсын стандарт хэмжилзүйн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрөөс баримтлах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Стандарт хэмжилзүйн газрын стратегийн бодлого чиг үүргийг орон нутаг хэрэгжүүлэн ажилладаг юм. Стандарт, хэмжил зүйн салбарын хамт олон бид Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, сорьцын

хяналт, итгэмжлэл, баталгаажуулалтын бодлогоор дэмжлэг үзүүлэх болон олон улсын нийтлэг чиг хандлагтай уялдуулан хөгжүүлэхээр ажиллаж байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгохтой холбогдуулан тус газар нь 2015-2018 оны тайлант жилд энэхүү дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнд хүрэх зорилго тавьж, байгууллагын үйл ажиллагаа болон түүний үр дүнг ил тод нээлттэй байлгах, түүнд зарцуулах хөрөнгийг үр ашигтай зарцуулах бодлого чиглэл баримталж байна.

Дархан-Уул аймгийн эдийн засаг нийгмийн амьдрал, төлөв, хөгжлийн талаар хэмжилзүй, баталгаажуулалт, стандарт чанарын бодлогоор дэмжлэг үзүүлж, Европын холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол улсад нэвтрүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөөн, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжих, нэр хүндийг нь өсгөх, хэмжлийн нэгдмэл байдлыг бий болгох, хүн амын эрүүл мэнд хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, бизнест ээлтэй орчин бүрдүүлнэ гэсэн эрхэм зорилгоо ханган ажиллаж байна.

Үйл ажиллагааны тодорхойлсон түвшин хөтөлбөрийг өгөгдсөн тоо хэмжээ, чанар, цаг хугацааны үзүүлэлтийн хүрээнд нийлүүлэхийн тулд эталон хэмжих хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн түвшинг сайжруулах, улсын шалгагч, шинжээчдийг мэдлэг боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын үндсэн дээр өрсөлдөөний зарчмаар шалгаруулан томилох, ажлын үр дүнг бодитойгоор дүгнэх, тэдгээрийг сургаж мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулахтай холбоотой авах арга хэмжээг мөн энэхүү хэтийн төлөвлөгөөнд тусгасан болно.

ШУУД ЗАХИРАГЧ

И.АЛТАНЦЭЦЭГ

## Нэг. Ерөнхий хэсэг

### 1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага:


- Монгол Улсын Хэмжлийн нэгдмэл байдлын хангах тухай хууль, Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх
- МУ-ын Засгийн газрын ба аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрүүдэд тавьсан зорилтыг хэрэгжүүлэх
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 344 дугаар тогтоол “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх.
- Төрийн удирдлагын үйл ажиллагааны шинэтгэлийг гүнзгийрүүлж, бүх шатны менежментийг сайжруулж, “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9000 стандарт”-ын шаардлагыг байнга ханган ажиллахад хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага оршиж байна.

### 2. Хөтөлбөрийн зорилго

- Хэлтсийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон байгууллагын менежментийг боловсронгуй болгож ,өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.
- Хэлтсийн эрхэм зорилго, стратеги зорилтуудад нийцсэн үйл ажиллагааг системтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх.
- Хөгжлийн чиг хандлага, стратеги зорилтуудад нийцүүлэн байгууллагын менежментийн нөөцийг зүй зохистой, үр өгөөжтэй удирдах.

**Зохион байгуулалтын хүрээ, эрх зүйн үндэслэл**

Схем-1



### Эрх зүйн үндэслэл

- Үндсэн хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Үндэслэл болгон харгалзан үзсэн төр засгийн шийдвэрээр баталсан баримт бичгүүд нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”;
2. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
3. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” ;
4. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” ;
- 5 . Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Газрын 2016 -2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”;
6. Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолоор баталсан” Үндэсний чанарын хөтөлбөр”

## **СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД:**

### **АЛСЫН ХАРАА**

Үндэсний болон олон улсад бүтээгдэхүүн ажил үйлчилгээ, хэмжүүр хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшнээр манлайлан, улс орны хөгжлийг хөтөлж хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.

### **УРИА**

Чанар - бидний зорилт

## **ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ**

### **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралд стандартчилал, хэмжилзүй, баталгаажуулалт, чанарын бодлогоор дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжих, нэр хүндийг нь өсгөх, хэмжлийн нэгдмэл байдлыг бий болгох, хүн амын эрүүл мэнд хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад оршино.

### **БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

- Нийгмийн эрх ашигт нийцэх;
- Бие даасан, хараат бус байх;
- Хариуцлагатай байх
- Шударга, ёс зүйтэй байх

## ТҮҮХЭН ТОВЧООН:

Стандарт, хэмжилзүйн хэлтэс нь 1977 онд Өмнөд Увс аймагт Ерөнхий Газрын харъяа салбар нэртэйгээр анх байгуулагдан, хэмжүүр, хэмжих хэрэгслийг засварлан тохируулж, баталгаажуулах үүрэгтэйгээр Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгийг хариуцан ажиллахаар салбарын даргаар н.Нямгүр, анхны ажилтнаар И.Маналжав, И.Мядаг нар томилогдон ажиллаж эхлэсэн байна.

1981 онд АХГЗ-ын Үнэ, Чанарын хэлтэс,

1983 онд АХГЗ-ын Үнэ, Чанарын хэлтсийн дэргэдэх Сорилтын лаборатори,

1992 оны Монгол улсын Засгийн газрын “Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв байгуулах тухай” 83 дугаар тогтоолын дагуу Дархан хотын Стандарчилал, Хэмжилзүйн Төв нэртэйгээр өөрчлөгдөн,

2001 онд Чанар баталгаажуулалтын алба,

2005 онд МХГ-ын хими, бактериологи, ургамал хорио цээрийн лабораторийг аймгийн Засаг даргын 358 тоот захирамжаар СХТөвийн лабораторитой нэгтгэн “Сорилтын нэгдсэн лаборатори”-ийг байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр

2008 онд Монгол Улсын Засгийн Газрын 67-р тогтоолоор Стандарчилал хэмжилзүйн хэлтэс

2016 онд Монгол Улсын Засгийн Газрын 9-р тогтоолоор Стандарт, хэмжилзүйн хэлтэс болон зохион байгуулагдсан.

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс нь:

- Захиргааны алба
- Баталгаажуулалтын алба
- Хэмжилзүйн алба

Стандартын мэдээлэл, лавлагааны салбар сан гэсэн 4 нэгжтэй, 18 орон тоотой ажиллаж байна

### **ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Дархан-Уул аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс нь баталгаажуулалтын алба, хэмжилзүйн нэгдсэн лаборатори, мэдээлэл лавлагаа салбар сан, санхүү захиргаа аж ахуй гэсэн бүтэцтэй, 18 орон тоотойгоор, орон нутагтаа Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, хуулийг хэрэгжүүлэхээр дагаж гаргасан ЗГ-ын тогтоол, дүрэм журмуудын хэрэгжилтийг хангуулан, Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоолоор баталсан хүний амь нас, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй 20 нэр төрлийн бүтээгдэхүүн, 12 нэр төрлийн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулахаас 19 нэр төрлийн бүтээгдэхүүн, 10 нэр төрлийн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулан, баталгаажуулалтыг 89 хувь, Хэмжилзүйн зөвлөлийн 2013 оны А/11 дугаар тогтоолоор баталсан 33 нэр төрлийн хэмжүүр хэмжих хэрэгслийг баталгаажуулахаас 24 нэр төрлийг хамруулан баталгаажуулалтыг 81,8%-тай гүйцэтгэж байна.

Мэдээлэл лавлагаа салбар сангаар иргэд, ААН, байгууллагад стандартын сургалт мэдээлэл явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүднээс лавлагааны танхимыг ажиллуулж байна. Ингэснээр чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн байгууллагын тоо 9, үндэсний тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний тоо 27 байна.

Энэ нь тухайн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчний хангалт дутмаг, эталон тоног төхөөрөмж байхгүйн улмаас зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэмжүүр, хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийгдэхгүй байна.

#### **Стратегийн зорилт 1:**

Эталоны хангалт, нарийвчлалыг үндэсний эталоны түвшинд ойртуулах, үндэсний эталонгоос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ**

1. Хэмжилзүйн лабораторийн эталоны хангалтыг сайжруулж, лабораторийн чадавхийг дээшлүүлэх, төсөл хөтөлбөр боловсруулан, үе шаттай хэрэгжүүлэх



2. Хэмжилзүйн лабораторийн итгэмжлэлийн хүрээг тэлж, хэмжүүр хэмжих хэрэгслийн шинэчлэлт, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг ханган шинэ эталонуудаар хангагдах

### **Стратегийн зорилт 2:**

Улсын Баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах;

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ***

1. Загварын туршилтанд хамрагдсан хэмжүүр хэмжих хэрэгслийг иргэдэд мэдээллэж, сурталчилах
2. Үндэсний хэмжээний лаборатори хоорондын ур чадварын сорилтод хамрагдах
3. Нэгж дамжуулалт болон хэмжлийн үр дүнгийн найдвартай байдлыг хангах

### **Стратегийн зорилт 3:**

Мэргэшсэн, ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэж, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэх,

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ***

1. Авто үйлчилгээ, барилгын салбарын, органик, эко хүнсний чиглэлээр орон тооны бус, мэргэшсэн баталгаажуулалтын шинжээчдийг бэлтгэх,
2. Баталгаажуулалтын итгэмжлэлийн хүрээг тэлж, баталгаажуулалтын нэр төрлийг олшруулна.
3. Мэргэшсэн ажиллах хүчнээр хангах хүний нөөцийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;

### **Стратегийн зорилт 4:**

Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй эко бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

1. Аймгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгаруулалтыг явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

2. Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, уялдаа холбоог дээшлүүлэх замаар зөгийчдийн холбоотой хамтран зөгийн балыг брэнд болгох, эко бүтээгдэхүүнийг баталгаажуулах ажлыг эхлэх

#### **Стратегийн зорилт 5:**

ААН, байгууллагуудад евро стандарт, удирдлагын тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, энэ стандартыг нэвтрүүлсэн байгууллагын тоог нэмэгдүүлнэ.

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ***

1. Холбогдох мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай хамтран ААН-үүдэд мэргэжлийн ара зүйн зөвлөгөө өгч, сургалтуудыг шат дараатай зохион байгуулна. Хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан сургалт, сурталчилгааг үе шаттай зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тогтмол мэдээ байршуулах

2. Чанарын талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг өрнүүлж, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх; чанартай бүтээгдэхүүн хэрэглэх чиглэлээр хэрэглэгчдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, зөв дадал хэвшүүлэх;

#### **Стратегийн зорилт 6:**

Байгууллагын тоног төхөөрөмж, материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ***

Мэдээлэл, лавлагаа, салбар сан болон тохирлын үнэлгээний ажилд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, материаллаг баазыг бэхжүүлэх;

Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах замаар төрийн албаны тогтвортой байдлыг хангах;

#### **Хүрэх үр дүн:**

1. Хэмжүүр баталгаажуулалтын ажлын чанар сайжирч, хэрэглэгчдийг найдвартай хэмжүүрээр хангах, хэмжүүрийн нарийвчлал дээшлэн үндэсний эталоны түвшинд ойртоно.

2. Буруу хэмжлийн сөрөг үр дагаврын эрсдлээс эдийн засаг, нийгэм, хэрэглэгчдийг хамгаалж, хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдал хангагдана.

3. Ажилтнуудын ур чадвар дээшилж, сургалтын орчин, материаллаг бааз бэхэжсэн байна;

4. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон олон нийтийн чанар, тохирлын үнэлгээний талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна;

5. Тогтолцооны стандартуудыг хэрэгжүүлсэн байгууллагын тоо нэмэгдэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар дээшилсэн байна;

Дархан-уул аймгийн иргэд хөдөлмөрчид үнэн зөв стандарт, технологийн мэдээллээр шуурхай хангагдан тэдний боловсрол технологийн түвшин дээшилж бүтээгдэхүүн үйлчилгээний чанар сайжирна.

Хөгжингүй орноос технологи дамжигдан, аж ахуй нэгжүүдийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, өндөр чанар, бага өртгийг хангахад тусалж, аймаг бүс нутгийн хөгжлийг дэмжинэ.